

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”,
“Засгийн газраас олгосон векселийн үр дүн”



Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дорноговь аймгийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Ахлах аудитор Ц.Лүндэгмаа Шинжээч П.Энхбаяр 2017 оны 4 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3- р байр	<i>Товчилсон үгийн тайлбар5</i> <i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....6</i> БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан судалж, үнэлэх, үр ашгийг тооцож, санхүүжүүлэх эх үүсвэрээ оновчтой хуваарилж төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулж байна. Бүлэг 1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 1.1 ТАХ-нь нэгдсэн бодлого, урт болон дунд хугацааны хөтөлбөртэй уялдсан байна.-----7-7 1.2 Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлага, хөрөнгийн хангамж зэргийг харгалзах шаардлагатай байна.-----8 1.3 Техникийн нөхцөл нь бүрэн олгогдоогүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.-----8 1.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим ТАХ-ний зураг төсөлд магадлал хийгдээгүй байна.-----8-9 1.5 Гүйцэтгэгч ажлын тоо хэмжээг өөрчлөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нэмэлт ажил гүйцэтгэж төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна.-----9 1.6 Аймаг, сумын ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний жагсаалтад нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил ангилалд өөрчлөлт ороогүй байна.----- 9 1.7 Шилжиж ирсэн, чанаргүй хийгдсэн ажлуудын үлдэгдэл санхүүжилтийг олгохоор төсөв баталсан байна.-----10 Бүлэг 1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1.1 Төсөл арга хэмжээг аймаг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан ч хуулиар заасан чиг үүрэгт хамаарахгүй 757.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөжээ.-----10-11 1.2 Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, үр өгөөжийн тооцоог урьдчилан судлаагүйгээс батлагдсан ТАХ хэрэгжээгүй, үр дүнгээ өгөөгүй байна.-----11-12 1.3 Аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудад газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна.-----12 1.4 Зураг төсөл, хяналтын төсөвгүй ажлуудад хөрөнгө оруулалтын төсөв баталсан байна.-----12-13 1.5 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-нд төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмсэн, санхүүжих дүнд өөрчлөлт оруулсан зөрчил байхгүй байна. -----13 1.6 Аймаг, сумын ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний жагсаалтад нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил ангилалд өөрчлөлт ороогүй байна.-----13 1.7 Шилжиж ирсэн, чанаргүй хийгдсэн ажлуудын үлдэгдэл санхүүжилтийг олгохоор төсөв баталсан байна.-----13-14 Бүлэг 1. Дүгнэлт-----15 Бүлэг 1. Зөвлөмж-----15 БҮЛЭГ 2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдсан байна.
---	--

Бүлэг 2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт

2.1 Захиалагчийн эрх шилжиж ирсэн 105.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажилласан байна.-----16

2.2. Аймгийн Цагдаагийн газар эрх шилжсэн ажлын ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын заалтыг мөрдөж ажиллаагүй байна.-----16-17

2.3 Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан байна-----17

2.4. Худалдан авах ажиллагаанаас 4.6 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна-----17

2.5 Бэлтгэл ажил хангагдаагүй ТАХ-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.-----17-18

2.6 ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ны зориулалтыг өөрчлөөгүй байна.-----18

Бүлэг 2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

2.1 Үнэлгээний хороог журмын дагуу байгуулж ХАА-ны аргыг зөв сонгосон байна.-----18

2.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж үнэлэхдээ хуулийн холбогдох заалтуудад илүү анхаарах хэрэгтэй байна.-----19

2.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад өмнөх оноос ахиц гарсан байна.-----19

2.4. Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг ТАХ-ний төсвийг нэмэгдүүлэх, мөн шинээр хийгдэх ажлын санхүүжүүлтийн эх үүсвэр зэрэгт тодотгон ИТХ-аар баталсан байна.-----20

2.5.Худалдан авах ажиллагааны эрхийг хугацаа алдалгүй шилжүүлжээ.-----20

2.6 Аймаг, сумын ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын ажлуудад ХАА зохион байгуулахдаа зориулалтыг өөрчлөөгүй байна.-----20

Бүлэг 2. Дүгнэлт-----20

Бүлэг 2. Зөвлөмж-----20

БҮЛЭГ 3. Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зарим хэсгийг бүрэн ашиглаагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

Бүлэг 3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт

3.1. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцон ажиллаагүй байна.-----21

3.2.Захиалагчийн эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тооцож олгосон байна.-----21

3.3. Хуваарилагдсан санхүүжилтийг ондоо багтааж бүрэн авахын тулд хуурамч гүйцэтгэл бичиж комиссын акт үйлдсэн байна.---22

3.4. Орон нутагт хэрэгжүүлж байгаа зарим ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсан, зургийн төслийн алдаа, санхүүжилт оройтох зэргээс шалгаалж хэрэгжих хугацаа хойшилсон байна.-----23

3.5 Зарим ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, гэрээг дүгнэж ажиллаагүй байна.-----23

3.6 ТАХ-г улсын комисс холбогдох дүрмийн дагуу хүлээн аваагүй байна.-----24

3.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим хөрөнгө чанар болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.-----24-25

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт-----25

Бүлэг 3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

3.1. Гэрээний нөхцөл тодорхойгүй, талууд гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчил гарсаар байна.-----	26
3.2. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөлт нь тооцоо, судалгаагүй хийгдсэнээс санхүүжих эх үүсвэр дутагдаж төсвийн гүйцэтгэл 69.1 хувьтай байна. -----	26-27
3.3. Хөрөнгө оруулалтын ажлуудад тавих хяналт хангалтгүйгээс гүйцэтгэл дутуу, гэрээний үүргээ биелүүлээгүй байхад урьдчилгаа санхүүжилт олгож үргүй зардал гаргасан байна-----	27-28
3.4. Сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 7 жил үргэлжилж байна.-----	28
3.5. ТАХ-ний гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас чанаргүй ажил хийгдэх, гэрээний хугацааг хэтрүүлэх, ажлаа дутуу гүйцэтгэх зөрчил гарсаар байна. -----	28-29
3.6 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн ажлуудад улсын комисс хүлээж аваагүй байхад ашиглалтад оруулсан болон санхүүжилтийг бүрэн олгосон ТАХ байхгүй байна. --	29
3.7 Зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй, данс бүртгэлд тусгагдаагүй байна.-----	29-31
Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт-----	31-32
Бүлэг 3. Дүгнэлт-----	32
Бүлэг 3. Зөвлөмж-----	32
БҮЛЭГ 4. Векселиэр санхүүжүүлж, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах боловсон хүчний мэдлэг, ур чадвар дутагдсанаас хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөж хангалтгүй байна.	
A.1 УИХ, ЗГ-ын тогтоолоор нийт 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г эрх шилжүүлэн векселиэр санхүүжүүлэхээр батлагдсан байна.-----	33-34
A.2 Векселиэр санхүүжүүлэхээр ЗГ-ын тогтоолд тусгагдаж байсан ТАХ-г МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад тусгаж баталсан байна. ---	34
A.3 МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, УИХ болон ЗГ-ын тогтоолд эрх шилжүүлсэн ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүн нэмэгдэж батлагдаагүй байна.-----	35
A.4 Орон нутагт эрх шилжүүлэн векселиэр санхүүжүүлэх ТАХ хууль болон ЗГ-ын тогтоолд давхар тусгагдаагүй байна.-----	35
Б.1 Гүйцэтгэл гараагүй ТАХ-г векселиэр санхүүжүүлсэн байна.---	35
Б.2 Төсвийн тухай хууль, УИХ, ЗГ-ын тогтоолоор батлагдсан ТАХ-г векселиэр санхүүжүүлсэн байна.-----	35
Б.3 Векселиэр санхүүжүүлсэн зарим ТАХ-ийн ашиглалт хангалтгүй, зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. -----	36
Б.4 Векселиэр олгосон санхүүжилт, БУА-ын гэрээгээр олгох нийт санхүүжилтийн дүнгээс хэтрээгүй байна.-----	36
Бүлэг 4. Дүгнэлт-----	37
Бүлэг 4. Зөвлөмж-----	37
Ерөнхий дүгнэлт-----	38
Ерөнхий зөвлөмж-----	39
Холбогдох байгууллагын санал-----	
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар-----	

Товчилсон үгийн тайлбар

ХО	Хөрөнгө оруулалт
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ХА	Харьцуулалтын арга
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
АЗЗА	Авто зам засвар арчлалт
ОНТ	Орон нутгийн төсөв
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
АХБ	Азийн хөгжлийн банк
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
БСШУСС	Боловсрол шинжлэх ухаан спортын сайд
ХАА	Худалдан авах ажиллагааны алба
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол улс
Век	Вексель
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайд
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үздэслэл
БХТ	Барилгын хөгжлийн төв
БУА	Барилга угсралтын ажил
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
СТСХ	САНхүү төрийн сангийн хэлтэс
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗАА	Захирагчийн ажлын алба
ҮАГ	Үндэсний аудитын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Үндэсний аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Засгийн газраас олгосон векселийн үр дүн”сэдэвтгүйцэтгэлийн аудит хийв.

Аудитын зорилт:

“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Засгийн газраас олгосон векселийн үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
2. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
3. Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,

Хамарсан хүрээ:

Тус аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ, Дорноговь аймаг дахь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг хамрууллаа.

Аргазүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын аргазүйг ашиглан холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, санхүүгийн албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судлах, дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж өглөө.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан судалж, үнэлэх, үр ашгийг тооцож, санхүүжүүлэх эх үүсвэрээ оновчтой хуваарилж төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулж байна.

БҮЛЭГ 1.1 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Орон нутагт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим ТАХ-г хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна.

1.1 ТАХ-нь нэгдсэн бодлого, урт болон дунд хугацааны хөтөлбөртэй уялдсан байна.

1.1.1 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт 5.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагджээ. Үүнээс 1.6 тэрбум төгрөгийн 7 ТАХ-г хэрэгжүүлэхээр салбар яамдаас захиалагчийн эрхийг тус аймагт шилжүүлсэн байна.

1.1.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2014-2016 онд хийгдэх төсөл, арга хэмжээний талаар 4 яамтай хамтран 14 сумын иргэдээр хэлэлцүүлэг зохион байгуулж, ач холбогдолоор нь эрэмбэлэн хөрөнгө оруулалтын жилийн төлөвлөгөөнд тусгуулжээ.

1.1.2 Тус аймгаас улсын төсвийн хөрөнгөөр 42.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 36 ТАХ-г хэрэгжүүлэх саналыг ЭЗХЯ-нд хүргүүлснээс 3.2 тэрбум төгрөгийн 7 ТАХ нь 2016 оны төсвийн тухай хуулиар батлагджээ. Үүнээс 4 ТАХ нь шинээр эхлэх, 3 ТАХ нь өмнөх оноос шилжин ирсэн ажлуудын үлдэгдэл санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн байна.

1.1.3 Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичгийн 4.4.1-д “Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох, хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, хэмжээ, байршлыг оновчтой болгосон цэцэрлэг, сургуулийн зураглалыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд заасны дагуу Сайншанд сумын 3, 6 дугаар цэцэрлэгийн барилгын засварын ажил хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Мөн бодлогын баримт бичгийн 4.5-д “Эмнэлэг, лабораторийн тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгож, оношилгооны чадавхийг сайжруулах” гэж заасны дагуу “Цахим эрүүл мэнд хөтөлбөр”, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” хөтөлбөрийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэхээр төлөвлөсөн байгаа нь бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

1.2 Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлага, хөрөнгийн хангамж зэргийг харгалзах шаардлагатай байна.

1.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүчин чадал, хөрөнгийн хангамж, орон нутгийн онцлог, урьд онуудад хуваарилагдсан хөрөнгө, эрэлт хэрэгцээ зэргийг судлалгүйгээр төлөвлөж байна.

1.2.2 Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс хөрөнгө илүүдэх, ашиглагдахгүй олноор хадгалагдах зэрэг байдал үүсч байна. Тухайлбал: БСШУСС-ын багцаас орон нутагт 688.0 сая төгрөгийн, ЭМС-ын багцаас 1118.6 сая төгрөг, НХХС-ын багцаас 55.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт нийлүүлсэн байна. Үүнээс 260.0 сая төгрөгийн 83 тоног төхөөрөмж боловсролын байгууллагад, 103.2 сая төгрөгийн 3 тоног төхөөрөмж эрүүл мэндийн салбарт ашиглагдаагүй, шинээрээ хадгалагдаж байна.

1.2.3 Мөн тухайн орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан төлөвлөөгүйгээс Сайншанд сумын Зүүнбаян багт барихаар төлөвлөсөн Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байрыг Хатанбулаг сумын Ханги боомтод шилжүүлэн хэрэгжүүлэхээр болсон байна.

1.3 Техникийн нөхцөл нь бүрэн олгогдоогүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3.1 МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Орон нутгийн сумдын цагдаагийн байр, кобан /VIII.2.1.2-8-2/ / ТАХ-ний хүрээнд Хатанбулаг, Сайхандулаан сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цагдаагийн хэсгийн байр барих ажлуудад цахилгааны эх үүсвэрт холбох техникийн нөхцөл олгогдоогүй байна. Харин газрын хэмжээ, байршлыг сумдын ИТХ-аар баталж, зөвшөөрөл олгосон байна.

1.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим ТАХ-ний зураг төсөлд магадлал хийгдээгүй байна.

1.4.1 Орон нутгийн сумдын цагдаагийн байр, кобан /улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд Сайхандулаан, Хатанбулаг сумын Ханги боомт дээр баригдах Цагдаагийн хэсгийн барилгын зурагт магадлал хийгдээгүй, мөн батлагдсан хяналтын төсөвгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25.2.1-д “.... заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг, төсөл,...инженерийн тооцоо өртгийн төсөвт”, 25.2.5-д “.... хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөвт магадлал хийнэ” гэж заасныг зөрчиж байна.

1.4.2 Улсын төсвийн хөрөнгөөр 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлын төсөвт өртөг нь 3578.2 сая төгрөг бөгөөд төсвийн дүнд инженерийн шугам сүлжээ, хамгаалалтын хашааны өртөг тусгагдаагүй байсан. Уг төсөвт 2016 онд магадлал хийлгэснээр 544.0 сая төгрөг нэмж батлагдсан байна.

1.4.3 Хилийн 0168 дугаар ангийн эмнэлэг, 24 машины гараж, засварын газар, халуун усны барилга /Дорноговь, Хатанбулаг сум/: БХТ-ийн баталсан 2014 оны 1743/2014 тоот Магадлалын ерөнхий дүгнэлтэд 36 х 15 м хэмжээтэй 2 давхар цэргийн байр, гал зуухны барилга шувуу нуруу дээвэртэй, 12.0м х 12.0м хэмжээтэй

1 давхар халуун ус, угаалгын барилга шувуу нуруу дээвэртэй, мөн 8.4*8.4 хэмжээтэй усан сангийн барилга байна гэж тодорхойлжээ. Аудитын явцад дээрх 2 барилгад шувуу нуруу дээвэр хийгдээгүй, усан сангийн барилга баригдаагүй байв.

Орон нутагт холбогдох баримт байхгүй тул зураг төсөвт орсон өөрчлөлт, дахин магадлал хийсэн эсэх, гүйцэтгэл, санхүүжилтийг тодруулах нь зүйтэй.

1.5 Гүйцэтгэгч ажлын тоо хэмжээг өөрчлөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нэмэлт ажил гүйцэтгэж төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна.

1.5.1 Улсын төсвийн 2013 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн А блокын 2,3-р давхар, мэс заслын тасаг, яаралтай түргэн тусламжийн тасгийн засварын ажлыг Тобем ХХК 192.3 сая төгрөгөөр гүйцэтгэж, 2013 оны 10-р сарын 07-ны өдрийн 58/2013 тоот комиссын актаар засварын ажлыг хүлээн авч нягтлан бодох бүртгэлд тусгуулсан байна.

Гэтэл 2016 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд нэгдсэн эмнэлгийн их засварын нэмэлт ажлын санхүүжилтэд 101.2 сая төгрөг батлагдсан байна. Ажлын гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчил илэрлээ.

- Гүйцэтгэгч 2013 онд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, зураг төсөвгүйгээр нэмэлт ажлыг ашиглагч байгууллагын саналыг харгалзан өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж засварын ажлын төсөвт өртгийг нэмэгдүүлсэн
- Захиалагч нэмэлт ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулаагүй, нэмэлт ажилд гэрээ байгуулаагүй, гүйцэтгэл гаргаагүй
- Аймгийн ГХБХБГ-ын тэргүүлэх төсөвчин Тобем ХХК-ийн нэмэлтээр хийж гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь хэмжилт хийж 101.2 сая төгрөгийн төсвийн тооцооллыг гаргасан
- БХТөвийн баталсан 2014-02-06-ны өдрийн 123/2014 дугаар бүхий Магадлалын ерөнхий дүгнэлтээр Нэмэлт ажлын тоо хэмжээг захиалагч болон ашиглагч байгууллагаар баталгаажуулах шаардлагатай гэсэн боловч нэмэлт ажлын тоо хэмжээг баталгаажуулах ажил хийгдээгүй байна.

1.6 МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх ТАХ-ний нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил зөрүүтэй тусгагдаагүй байна.

1.7 Хөрөнгө оруулалтын шилжих арга хэмжээнд 1194.5 сая төгрөг хуваарилахаар төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтын шилжих арга хэмжээнд дараах санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнд:

- МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IX.1.12 дэх хэсгийг үндэслэн БХБС-ын тушаалаар Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажилд 295.0 сая төгрөг,
- Замын-Үүд сумын Соёлын төвийн барилгын ажилд 899.5 сая төгрөгийг хуваарилсан.

Захиалагчийн эрх шилжиж ирсэн ТАХ-нд дараах санхүүгийн нөөцийг хуваарилсан байна. Үүнд:

- МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулийн XII.1.2.2 дахь хэсгийг үндэслэн БСШУС-ын 2016 оны А/81 тоот тушаалаар Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэгийн шинэчлэлт засварт 25.6 сая төгрөг,
- Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засварт 80.0 сая төгрөг,
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн их засварын нэмэлт ажлын санхүүжилт 101.2 сая төгрөгийн баталж хуваарилсан байна.

БҮЛЭГ 1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөлгүй, ТЭЗҮ-гүй, үр ашигтай эсэх нь тодорхой бус ТАХ-г тусган баталж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулах нөхцөл болж байна.

1.1 Төсөл арга хэмжээг аймаг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан ч хуулиар заасан чиг үүрэгт хамаарахгүй 757.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөжээ.

1.1.1 Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2016 онд хэрэгжүүлэх 43 төсөл арга хэмжээнд 2123.3 сая төгрөгийн, Замын-Үүд сумын ИТХ-ын тогтоолоор 42 төсөл арга хэмжээнд 631.8 сая төгрөгийн, нийт 85 ТАХ-нд 2755.1 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталжээ.

1.1.2 Төсвийн тухай хуулиар тодорхойлсон аймаг, сумын өөрийн төсвөөр тухайн шатанд хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох, их засвар хийх, шинээр өмч бий болгох, сумын тохижилт, мод ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн засвар, арчилгаа хийх чиглэлээр хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн байна.

1.1.3 Харин Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний 27.5 хувь буюу 757.5 сая төгрөгийн 18 арга хэмжээг улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулахаар төлөвлөсөн байна. Үүнээс аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 499.1 сая төгрөгийн 6 ТАХ, Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 258.4 сая төгрөгийн 12 ТАХ байна.

1.1.4 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх ТАХ-г аймгийн Засаг даргын “Шинэ Дорноговь-2” тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг, эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ.

Тухайлбал:

- Иххэт сумын спорт цогцолборын барилга угсралтын ажил
- Мандах сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажил
- Саран хөхөө театрт үзэгчдийн сандал нийлүүлэх
- 3D-4D кино театр байгуулах
- Сайншанд сумын Аюушийн гудамжинд авто зам барих

- Сайншанд сумын 2-р багийн айл өрхийг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох
- Багийн дарга нарыг унаажуулах

1.2 Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, үр өгөөжийн тооцоог урьдчилан судлаагүйгээс батлагдсан ТАХ хэрэгжээгүй, үр дүнгээ өгөөгүй байна.

1.2.1 Хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагаа урьдчилан судалж, үнэлж, нэн тэргүүний шаардлагатай төсөл арга хэмжээг тодорхойлох, зорилго зорилттойгоо нийцүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашгийг нь тооцох, санхүүжүүлэх эх үүсвэрээ оновчтой хуваарилах нэгдсэн бодлого дутагдсанаас хөрөнгө оруулалтыг үр ашиггүй, үр өгөөжгүй болгож байна. Тухайлбал хөрөнгө оруулалт нь эдийн засаг, хууль эрх зүй, үйл ажиллагаа, цаг хугацаа, хүн хүчний хувьд хэрэгжих боломжтой эсэхийг судлан тооцож төлөвлөөгүй байна.

1.2.2 Аймгийн ИТХ-аас баталсан Сайншанд сумын 3-р 58 айлын орон сууцны дээврийн засварын 25.0 сая төгрөгийн, 3-р багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны шугаманд холбох 43.8 сая төгрөгийн, 5-р багт гудамжны гэрэлтүүлэг хийх 18.5 сая төгрөгийн, нийт 87.3 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байна.

1.2.3 Замын-Үүд суманд хэрэгжүүлэхээр баталсан төсөвт арга хэмжээний 16.8 хувь нь буюу 105.9 сая төгрөгийн ТАХ хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн байна. Үүнд:

Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ-81.4 сая төгрөг

- Дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж эхлэх 10.0 сая төгрөг;
- Шинээр газар олголт хийсэн газарт ус түгээх цэг шинээр барих, цэвэр усны шугам татах 5.0 сая төгрөг;
- Түрээсийн байрыг санхүүжүүлэх 6.4 сая төгрөг;
- Дараа жилийн хийгдэх ажлын зураг төсөв хийх 30.0 сая төгрөг;
- Соёлын төвийг түрээслэх, тохижуулах 30.0 сая төгрөг;

Дутуу хэрэгжсэн -24.5 сая төгрөг

- Орон сууцаар хангах асуудлыг шийдвэрлэх 15.0 сая төгрөг;
- Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан мэдээлэх 2.4 сая төгрөг;
- Чацаргана тариалах 3.1 сая төгрөг;
- Хүнд даацын авто замын дагуу ногоон байгууламж байгуулах 4.0 сая төгрөг;

1.2.4 Аймгийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөр арга хэмжээнд он дараалан тусгагдаж хэрэгжсэн гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ТАХ-ний хүрээнд айл өрхүүд шугам сүлжээнд холбогдох боломж нөхцөл бүрдсэн хэдий ч ашиглалт хангалтгүй байна.

- Сүүлийн 3 жилийн байдлаар Сайншанд сумын 1, 2, 3 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэлд нийт 225.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2013-2017 онуудад цэвэр, бохир усны шугамд холбогдсон 39 айл өрх байна. /Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн борлуулалтын нягтлан бодогчоос тоо мэдээг авав/

Сайншанд сумын багууд	Цэвэр, бохир усны шугамын өртөг /сая төгрөг/	Холбогдсон айл өрхийн тоо	
		Цэвэр усны шугам	Бохир усны шугам
1-р баг	39.0	18	7
2-р баг	156.0	0	0

3-р баг	30.0	21	0
Дүн	225.0	39	7

1.3 Аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудад газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна.

1.3.1 Шинэ барилга, шугам сүлжээний ажлуудыг гүйцэтгэх ТАХ-ний техникийн нөхцөл олгогдсон байна.

- Иххэт сумын Спорт цогцолборын барилга угсралтын ажилд газар эзэмшүүлэх гэрээ, дулаан, цэвэр бохир ус, цахилгаан хэрэгслээр хангах техникийн нөхцөл гаргуулсан байна.
- Сайншанд 2-р багийн айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох ажилд Бага нуур зүүн өмнөд бүсийн ЦТС ТӨХК-ийн Дорноговь салбар, Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-аар гаргуулсан
- Алтанширээ, Дэлгэрэх сумдын ЦДАШ-ын өргөтгөлийн ажилд Бага нуур зүүн өмнөд бүсийн ЦТС ТӨХК-ийн Дорноговь салбараар гаргуулсан

1.4 Зураг төсөл, хяналтын төсөвгүй ажлуудад хөрөнгө оруулалтын төсөв баталсан байна.

1.4.1 АИТХ-д хүргүүлсэн 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлуудын зарим зураг төсөл, хяналтын төсвийн баримт материал байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчиж байна.

1.4.2 Төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөвгүй ажлуудад ИТХ-аас төсөв баталснаас ХАА зохион байгуулахад хүндрэлтэй, цаг хугацаа алдахад сөргөөр нөлөөлдөг, баталсан санхүүжүүлэх эх үүсвэрт тохируулж хяналтын төсөв хийгддэг байна.

1.4.3 Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 217.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээнд хяналтын зураг төсөв гаргаагүй байхад ИТХ-аас төсөв баталжээ. Үүнд:

- ЕБ-ын 1-р сургуулийн 60 жилийн ойд зориулсан тохижилт, засварын ажил 60.0 сая төгрөг
- Багуудын хаягжилтыг шинэчлэн хийх 40.0 сая төгрөг
- Наадмын талбайн дээврийн суудрэвч хийх 25.0 сая төгрөг
- Соёмбот цогцолборт тугны суурь хийх, эскитний талбай, дугуйн зам байгуулах 50.0 сая төгрөг
- Явган замын засварын ажил 2.8 сая төгрөг
- Тусгаар тогтнолын гэрэлтүүлгийн толгойг лед гэрлээр солих ажил 12.5 сая төгрөг
- 2,3,4-рцэцэрлэг, 2-р сургуулийн гадна гэрэлтүүлэг хийх ажил 8.8 сая төгрөг
- Шинээр газар олголт хийсэн газарт ус түгээх цэг шинээр барих, цэвэр усны шугам шинээр татах 5.0 сая төгрөг
- Сүлд багийн 8-р хэсгийн Хөвсгөл буудлаас бага сургуулийн 4 замын уулзвар хүртэлх явган зам хийх 13.5 сая төгрөг

1.4.4 Улсын төсвийн байгууллагаас ирүүлсэн хөрөнгийн дэмжлэг хүссэн жагсаалт, төсвийн тооцоонд үндэслэн бараа, ажил үйлчилгээний төсөв баталсан байна.

1.5 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-нд төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмсэн, санхүүжих дүнд өөрчлөлт оруулсан зөрчил байхгүй байна.

1.6 Аймаг, сумын ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний жагсаалтад нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил ангилалд өөрчлөлт оруогүй байна.

1.7 Шилжиж ирсэн, чанаргүй хийгдсэн ажлуудын үлдэгдэл санхүүжилтийг олгохоор төсөв баталсан байна.

1.7.1 Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудын гүйцэтгэлийн чанар байдал, нэн тэргүүний шаардлагатай ажил мөн эсэхэд тавих шат шатны хяналт хангалтгүйгээс санхүүгийн нөөцийг оновчгүй хуваарилсан, өмнөх жилээс шилжин ирсэн зарим ажлууд хийгдээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.

- Нэг иргэнийг малжуулахад 2.5 сая төгрөг,
- Хаяг хийж байршуулж нарийн гудамж гаргах ажилд 3.0 сая төгрөг,
- Цэвэр усны шугам татахад 5.3 сая төгрөг, хүлэмж барихад 3.0 сая төгрөг,
- Ногоон байгууламжийн ажилд 15.0 сая төгрөг.

1.7.2 Гүйцэтгэгч байгууллага баталгаат хугацаанд чанаргүй хийсэн ажлаа өөрийн хөрөнгөөрөө засаагүй байхад төсөв баталсан байна. Тухайлбал: Хүрэл цам ХХК 2013 онд Сайншанд сумын 3-р 58 айлын орон сууцны барилгын дээврийн засварын ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн ажилд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэхээр 25.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

1.7.3 Хөвсгөл сумын сургуулийн хичээлийн байр, спорт заал, цайны газрын засварын 91.8 сая төгрөгийн ажлыг 2015 онд хийж гүйцэтгэсэн ИХ хашаат ХХК-д үлдэгдэл санхүүжилт болох 25.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Тус компанид 2016 онд хийсэн аудитаар ГХБХБГ-т хариуцуулж барилгын дээврийн 40.6 сая төгрөгийн ажлыг дахин засварлуулах албан шаардлага өгсөн бөгөөд тус компани ажлаа хийж дуусгаагүй байж дуусгасан гэсэн албан бичиг үйлдэж санхүүжилтээ бүрэн авсан байна. Аудитаар тус компаний дахин гүйцэтгэсэн ажлын чанар байдалтай танилцахад ажил огт хийгдээгүй байна.

Барилгын гадна фасадны хормойн битүүлсэн хэсгийн шавар эргэн тойрон унасан, эмульс бороонд урсаж өнгөө алдсан, заалны хар цаасыг дахин янзлахдаа хуучин хар цаасыг эргүүлж наасан боловч бүгд дахин ховхорч унасан байна.

БҮЛЭГ 1. ДҮГНЭЛТ

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх ТАХ нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлага, хүчин чадал, хөрөнгийн хангамж, орон нутгийн онцлог, урьд онуудад хуваарилагдсан хөрөнгө зэргийг судлалгүйгээр хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ИТХ-нь хяналтын төсөв, зураг төсөлгүй, үр ашигтай эсэх нь тодорхой бус ТАХ-нд төсөв баталсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашгийг бууруулж байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад 757.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн нь төсвийн тухай хуулиар заасан орон нутгийн төсвийн чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

БҮЛЭГ 1. ЗӨВЛӨМЖ

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө хөрөнгө оруулалт хийгдсэнээр ямар үр дүнд хүрэх, техник, технологи, эдийн засаг, үйл ажиллагаа, цаг хугацааны хувьд хэрэгжих боломж байгаа эсэхийг судлах, хэрэгцээ шаардлагаа үндэслэлтэй тодорхойлох
2. Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний хяналтын зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл бүрэн байгаа эсэхийг нягтлан хянаж, бэлтгэл бүрэн хангагдсан, иж бүрэн, ТАХ-г Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон, аймаг, сумын ИТХ-д хүргүүлж байх
3. ОНТХ-өөр санхүүжүүлэх ТАХ-ний төсвийг төсвийн тухай хуулиар заасан чиг үүргийг баримтлан батлах

Бүлэг 2

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдсан байна.

БҮЛЭГ 2.1 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2.1 Захиалагчийн эрх шилжиж ирсэн 105.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажилласан байна.

2.1.1 МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан Боловсролын салбарын барилга байгууламжийн өргөтгөл засвар **XII.1.2.2.45-8-1** /улсын хэмжээнд/ ТАХ-ийн хүрээнд БСШУСС-ын 2016 оны 10-р сарын 20-ны өдрийн А/81 тоот тушаалаар Дорноговь аймгийн Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэгийн шинэчлэл, 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засварын ажлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

2.1.2. Аймгийн Засаг даргын 2016 оны А/493 захирамжаар захиалагчийн эрх шилжиж ирсэн дээрх ТАХ-ний ХАА-г зохион байгуулах үнэлгээний хороог захиалагч болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 5 хүний бүрэлдэхүүтэй байгуулсан байна. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулан 2016 оны 11-р сарын 03-ны өдөр харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

2.1.3 Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь захиалагчийн эрх шилжиж ирсэн дээрх ажлын тендерийн урилга, тендер шалгаруулалтын явцыг www.meps.gov.mn, www.e-procurement.mn цахим хуудаст мэдээлсэн байна.

2.1.4 МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Орон нутгийн сумдын цагдаагийн байр, кобан **VIII.2.1.2-8-2** /улсын хэмжээнд/ ТАХ-ийн хүрээнд ЦЕГ-ын 2015 оны 12-р сарын 31-ны өдрийн 9/1491 тоот албан бичгээр Сайхандулаан, Зүүнбаян багт цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кабон/-ны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг орон нутагт шилжүүлсний дагуу Аймгийн цагдаагийн газрын 2016 оны 1-р сарын 26-ны өдрийн А/05 тушаалаар томилогдсон үнэлгээний хороо ХАА-г харьцуулалтын аргаар зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2.2. Аймгийн Цагдаагийн газар эрх шилжсэн ажлын ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2.1 ЦЕГ-ын 2016 оны 04-р сарын 11-ний өдрийн 9/498 тоот албан бичигт Зүүнбаян багт баригдахаар төлөвлөгдөж байсан кобаны барилгыг Хатанбулаг сумын Ханги боомтод барихаар Хуульзүйн сайдын шинэчлэгдсэн хуваарь батлагдсан, тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах талаар дурьджээ. Гэтэл аймгийн Цагдаагийн газар Ханги боомт дээр баригдах

барилгын ХАА-г дахин зохион байгуулаагүй, 2016 оны 5-р сарын 11-ний өдөр Зүүнбаян багт шалгарсан гүйцэтгэгч Шунхлайн шандас ХХК-д гэрээ байгуулах эрхийг олгожээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.1-д *".....босго үнээс хэтрээгүй тохиололд харьцуулалтын аргыг хэрэглэж болно"*, мөн хуулийн 33.2.1-д *"техникийн тодрхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх"*, мөн хуулийн 33.2.2-д *"техникийн тодрхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох"* гэж заасныг тус тус зөрчиж байна.

2.3 Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан байна

2.3.1. Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэгийн шинэчлэл цахим тендерт 5 оролцогчийн материалыг хүлээн авч, захиалагчаас тавьсан шаардлагуудыг бүрэн хангасан, шаардлагад нийцсэн тендерээр Хул шанд ХХК-ийг, 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засварын ажлын цахим тендерт 5 оролцогч тендерийн материал ирүүлж, Айсуй хөгжил ХХК-ийг тендерт шалгаруулсан байна.

2.3.2. Аймгийн худалдан авах бараа, ажил үйлчилгээний 2016 оны төлөвлөгөөнд эрх шилжүүлсэн дээрх ТАХ-г тусгаагүй байна.

Захиалагчийн эрх шилжиж ирсэн тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд мэдээлсэн боловч ХАА-ны төлөвлөгөөнд тусгаадаагүй ХАА-ны талаархи тайлбар үндэслэлийг ХАА-ны тайланд тусгаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 264-р тушаалын 2.8-д *"Захиалагч тухайн жилд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж ажиллах бөгөөд төлөвлөгөөнд тусгаадаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэлийг худалдан авах ажиллагааны тайланд тодорхой тусгана"* гэж заасныг зөрчиж байна.

2.4. Худалдан авах ажиллагаанаас 4.6 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна

2.4.1 Дорноговь аймгийн Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэг шинэчлэл засварын ажил, 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засварын 105.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажилд гэрээний үнийн дүнгээр санхүүжилтийг БСШУСЯ-аас олгож, ХАА-наас 4.6 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

2.5 Бэлтгэл ажил хангагдаагүй ТАХ-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2.5.1 ЦЕГ-ын 2015 оны 12-р сарын 31-ны өдрийн 9/1491 тоот албан бичгээр Зүүнбаян багт цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кабон/-ны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг орон нутагт шилжүүлсэн. Аймгийн цагдаагийн газрын 2016 оны 1-р сарын 26-ны өдрийн А/05 тушаалаар томилогдсон үнэлгээний хороо 2-р сарын 26-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Гэтэл ЦЕГ-ын 2016 оны 4-р сарын 11-ний өдрийн 9/498 тоот албан бичгээр Зүүнбаян багт баригдах кабоны барилгыг Хатанбулаг сумын Ханги боомт дээр шилжүүлэн барихаар шийдвэрлэж, бэлтгэл ажил хангагдаагүй ТАХ-нд гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

2.5.2 БСШУСС-аас Сайншанд сумын 3, 6-р цэцэрлэгийн барилгын засварын ажлын ХАА-г зохион байгуулах эрхийг 2016 оны 10-р сарын 20-нд шилжүүлсэн бөгөөд ажил гүйцэтгэх гэрээг 2016 оны 11-р сарын 30-ны өдөр байгуулсан байна. ХАА-ны эрхийг хүйтний улирал эхэлсэн үед шилжүүлснээр гэрээний хугацаанд барилгын гадна заслыг БНБД-ын дагуу гүйцэтгэх боломжгүй болсон байна.

2.6 ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ны зориулалтыг өөрчлөөгүй байна.

2.6.1 Сайдын багцаас эрх шилжүүлсэн ажлын ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ны зориулалтыг өөрчлөөгүй байна.

БҮЛЭГ 2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад илүү анхаарах хэрэгтэй байна.

2.1 Үнэлгээний хороог журмын дагуу байгуулж ХАА-ны аргыг зөв сонгосон байна.

2.1.1 Аймгийн ИТХ-аас баталсан 2016 оны хөрөнгө оруулалтын 43 төсөл, хөтөлбөр арга хэмжээнээс 1798.8 сая төгрөгийн төсөв бүхий 25 арга хэмжээнд ХАА зохион байгуулагдсан байна.

2.1.2 Бараа, ажил үйлчилгээний төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас дээш үнэ бүхий төсөл арга хэмжээнүүдэд үнэлгээний хороог байгуулсан байна.

2.1.3 Аймагт зохион байгуулсан ХАА-аар 2016 онд нийт гэрээний 8 буюу 30.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын, 10 буюу 37.0 хувийг харьцуулалтын, 9 буюу 33.0 хувийг шууд гэрээ байгуулах аргаар тус тус шалгаруулжээ.

2.1.4 Замын-Үүд сумын ИТХ-аас 2016 онд санхүүжүүлэхээр баталсан нийт 631.8 сая төгрөгийн төсөв бүхий 42 төсөл арга хэмжээнээс 453.6 сая төгрөгийн 23 арга хэмжээнд ХАА зохион байгуулагдсан байна.

2.1.5 Замын-Үүд суманд ХАА-ны 1 буюу 4.3 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын, 6 буюу 26.0 хувийг харьцуулалтын аргаар, 16 буюу 69.7 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан байна.

2.1.6 Төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг 2016 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим худалдан авах ажиллагааны www.meps.gov.mn хуудсанд тухай бүр байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг Зууны мэдээ сонинд нийтэлжээ. Мөн орон нутгийн DSB, MNT телевизүүдээр урилгыг нэвтрүүлж, тендерийн талаарх сурталчилсан хэвлэмэл материал хэвлүүлж олон нийтэд тараасан байна.

2.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж үнэлэхдээ хуулийн холбогдох заалтуудад илүү анхаарах хэрэгтэй байна.

2.2.1 Замын-Үүд суманд хэрэгжүүлэх Газар тариалан эрхлэгчдийг дэмжих 16.6 сая төгрөгийн төсөв бүхий ажилд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа харьцуулалтын аргыг хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан байна.

2.2.2. Тендерт шалгарсан зарим компаниуд хөрөнгө, техник, хүн хүчний дутагдалтайгаас ажил гүйцэтгэх гэрээний хугацааг хэтрүүлэх, ажлын туршлагагүй байх зэргээс ТАХ-г чанаргүй гүйцэтгэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. Иймд аймаг суманд ХАА зохион байгуулж тендерийг үнэлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28.4-т заасан ажил үйлчилгээ дуусгах, бараа хүргэх хугацаа, зардал болон үр ашгийн тооцоо, борлуулалтын дараах үйлчилгээ, техникийн туслалцаа, бараа ажил үйлчилгээний чанар, техникийн үзүүлэлтийг нэмж тооцох, мөн гүйцэтгэлийн баталгаа гаргуулах нь зүйтэй байна.

2.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад өмнөх оноос ахиц гарсан байна.

2.3.1 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1-д “Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасны дагуу эдгээр онцлог шинж чанар бүхий төсөл, арга хэмжээ тус бүрт үнэлгээний хороог байгуулсан байв.

2.3.2 Аймгийн ХААА-наас худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ахиц гарсан байна. Тухайлбал: Үнэлгээний хороо байгуулсан өдрөөс хойш тендерийн урилга нийтэлсэн өдөр хүртэлх хугацаа багассан, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тендерт зарцуулсан хугацаа өмнөх жилээс ойролцоогоор 2 дахин бага байна.

Үзүүлэлт	2015 онд	2016 онд
100 дээш хоног зарцуулсан төсөл арга хэмжээний тоо	15	5
Төсөл арга хэмжээнд зарцуулсан хамгийн их хоног	256	160
Төсөл арга хэмжээнд зарцуулсан хамгийн бага хоног	32	23

2.3.3 Замын-Үүд сумын ХАА хариуцсан мэргэжилтэн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төсвийн тодотгол хийгдсэн байхад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийсэн, тодотгосон төлөвлөгөө гаргаагүй байна.

2.3.4 Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 3.2-т заасан худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн явцын мэдээлэл, тулгарч байсан бэрхшээл, цаашид анхаарах санал хүсэлтийн талаар аймаг, суманд бичмэл тайлан гаргаагүй байна.

2.4. Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг ТАХ-ний төсвийг нэмэгдүүлэх, мөн шинээр хийгдэх ажлын санхүүжүүлтийн эх үүсвэр зэрэгт тодотгон ИТХ-аар баталсан байна.

2.5.Худалдан авах ажиллагааны эрхийг хугацаа алдалгүй шилжүүлжээ.

2.5.1. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.6-д заасны дагуу аймгийн ЗДТГ-аас захиалагчийн эрх шилжүүлсэн 125.3 сая төгрөгийн төсөвтэй 6 ажил, Замын-Үүд сумын ЗДТГ-аас байгууллагуудад эрх шилжүүлсэн 157.8 сая төгрөгийн 8 ажил байна.

2.5.2. Дээрх ажлуудын худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэхдээ хугацаа алдаагүй байна.

2.5.3. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө биелэгдээгүй, санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байсан шалтгаанаар Сайншанд суманд эрх шилжсэн 43.8 сая төгрөгийн төсөв бүхий 3-р багийн 2-р хэсгийн гэр хорооллын цэвэр, бохир усны шугамын холболт хийх ажил, 18.5 сая төгрөгийн төсөв бүхий 5-р багт гудамжны гэрэлтүүлэг суурилуулах ажлуудын тендер шалгаруулалт зохион байгуулагдаагүй байна.

2.6 Аймаг, сумын ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын ажлуудад ХАА зохион байгуулахдаа зориулалтыг өөрчөөгүй байна.

БҮЛЭГ 2. ДҮГНЭЛТ

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаандаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.4-т заасан шалгуурыг харгалзан үзэх хэрэгтэй байна.

Үнэлгээний хороог журмын дагуу байгуулж ХАА-ны аргыг зөв сонгосон байна.

Замын-Үүд суманд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын ХАА-ны хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаагүй байна.

ЦЕГ-аас эрх шилжин ирсэн ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын заалтыг хэрэгжүүлээгүй байна.

БҮЛЭГ 2. ЗӨВЛӨМЖ

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад илүү анхаарах
2. Зохион байгуулсан ХАА-г журмын дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаж байх

Бүлэг 3

Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй,
хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зарим хэсгийг бүрэн ашиглаагүй,
данс бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ 3.1 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

3.1. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцон ажиллаагүй байна.

3.1.1. Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн БУА-ын 2016 оны гэрээний хугацааг 91 хоногоор сунгасан боловч гүйцэтгэгч АТТА ЧР ХХК барилгыг дуусган ашиглалтад өгөөгүй байна.

3.1.2. Хатанбулаг сумын Ханги боомтод Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр барих ажлын ХА-02/2016 тоот гэрээний хугацаа хэтэрсэн, сунгалт хийгдээгүй байна. Гүйцэтгэгч Шунхлайн шандас ХХК ажлаа хийж чадаагүй учир Пазл Солюшн ХХК-тай 2016 оны 12-р сарын 18-нд шууд гэрээ байгуулсан бөгөөд мөн гэрээг дүгнэж ажиллаагүй байна. Тус ажлын гүйцэтгэлийн баримт материалыг аймгийн Цагдаагийн газар аудитын явцад ирүүлээгүй болно. Иймд ажлын төсвийн тооцоог нарийвчлан үзэх саналыг ҮАГ-т уламжиллаа.

3.2.Захиалагчийн эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тооцож олгосон байна.

3.2.1. Дорноговь аймгийн хэмжээнд 2016 оны улсын төсвөөс 9981.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй захиалагчийн эрх шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээнд 1546.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 789.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 1		сая төгрөгөөр		
№	ТАХ-ны нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	2016 онд санхүүжүүлсэн дүн
1	960 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил Замын-Үүд сум	3578.3	295.0	295.0
2	3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэг шинэчлэлт засвар Сайншанд	25.8	23.5	23.5
3	6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат, довжоо, цахилгаан засвар Сайншанд	80.0	77.7	77.7
4	Соёлын төвийн барилгын ажил Замын-Үүд сум	5844.1	899.5	143.0
5	Аймгийн нэгдсэн эмнэлгийн их засварын нэмэлт ажил Дорноговь	293.5	101.2	101.2
6	Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кабон/-ны барилга Сайхандулаан сум	79.9	74.6	74.6
7	Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кабон/-ны барилга Хатанбулаг сумын Ханги боомт	79.9	74.7	74.7
	Дүн	9981.5	1546.2	789.7

3.3. Хуваарилагдсан санхүүжилтийг ондоо багтааж бүрэн авахын тулд хуурамч гүйцэтгэл бичиж комиссын акт үйлдсэн байна.

3.3.1. Захиалагчийн эрх тайлант оны 4-р улиралд шилжин ирсэнээр ХАА оройтож, улирлын чанартай хийгддэг БУА хугацаандаа хэрэгжих боломжгүй байдалд хүргэж байна.

Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засварын ажлыг Айсуй хөгжил ХХК 77.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч, 2016 оны 11-р сарын 30-ны өдрөөс 2016 оны 12-р сарын 20-ны өдөр ажлаа гүйцэтгэж дуусгахаар гэрээ байгуулжээ.

Санхүүжилтийг тайлант онд багтааж авахын тулд хуурамч гүйцэтгэл, барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын актыг бичиж санхүүжилтийг бүрэн олгосон байна. Аудитын явцад ажлын гүйцэтгэлийг шалгахад тус засварын ажил 2017 оны 4 сард дууссан байна. Иймд улсын комисс томилж ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу хүлээн авахыг ГХБХБГ-т даалгаж албан шаардлага бичив.

3.3.2. Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилт бүрэн олгосон байна. Тухайлбал: Соёлын танхим, номын сангийн заслын ажил дутуу, шалны хулдаас бүрэн наагдаагүй, сантехник, цахилгааны материал бүрэн татагдаж ирээгүйгээс угсралтын ажил хийгдээгүй байв.



Зураг 10. Сургуулийн барилгын явц

3.3.3. Ханги боотод баригдсан Цагдаагийн хэсгийн байрны барилгад зураг, төслийн дагуу дотор халаалтын ажил хийгдээгүй байна. Тухайлбал: Бага оврын нам даралтын тогоо тавих, даралтын насос байрлуулах, барилгын гадна шавардлага, шавар хаяавч, гараж руу орох хэсгийн бетон довжоо цутгах зэрэг ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

3.4. Орон нутагт хэрэгжүүлж байгаа зарим ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсан, зургийн төслийн алдаа, санхүүжилт оройтох зэргээс шалгаалж хэрэгжих хугацаа хойшилсон байна.

3.4.1 Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж байгаа барилга байгууламжийн гэрээний хугацааг жил бүр сунгадаг ч зарим ажил дуусаагүй 6 жил үргэлжилж байна.

Хүснэгт 2. Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Анх эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа	Гэрээний үнэ	Нийт олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл, хувиар
1	960 хүүхдийн ЕБСургууль /Замын-Үүд/	2013	2017	3578.3	3577.5	90
2	Төрөх эмнэлэг, 50 ор /Сайншанд/	2011	2015	1285.2	1285.7	40
3	100 ортой хүн эмнэлэг /Замын-Үүд/	2013	2016	4056	3423.1	75
4	Соёл спортын цогцолбор /Замын-Үүд/	2013	2016	5844.1	2437.4	40
5	Соёл, спорт цогцолборын барилга угсралт /Хатанбулаг сум/	2013	2014	913.4	849.4	85

3.4.2. Зарим ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулсан, нэмэлт ажил гарсан зэргээс төсөвт өртөг нэмэгдэж, ТАХ-ний хэрэгжилт удаашрах нэг шалтгаан болж байна.

- Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилга 2013 оноос эхлэн баригдаж байна. Гадна инженерийн шугам сүлжээний өртөг нь барилгын 3578.2 сая төгрөгийн төсөвт өртгийн дүнд тусгагдаагүй байсныг 2016 онд төсвийн тооцоог магадлалаар хянуулж 544.0 сая төгрөгийг нэмж батлагдсан байна. Зураг төслийн алдаанаас спорт залны өндөр 1 м дутуу байсныг автортой зөвшилцөн металл каркасыг буулгаж баганы өндрийг сунган дахин хийжээ.

3.5 Зарим ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

3.5.1 Захиалагчийн эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын зарим ажлын гэрээг дүгнээгүй, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаагүй байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний сунгалт” НТШ-12/2013-05 тоот гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулаагүй.
- Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлэг шинэчлэлт засварын ажлын УТ-ХА-01/2016 тоот гэрээг дүгнэж ажиллаагүй байна.
- Хатанбулаг сумын Ханги боомтод Хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ны барилгын ажил гүйцэтгэх ХА-02/2016 тоот гэрээг дүгнээгүй.

3.5.2 Сайншанд сумын 3-р цэцэрлэгийн барилгын засвар, 6-р цэцэрлэгийн барилгын засвар, Хатанбулаг сумын Ханги Боомтод баригдсан Цагдаагийн хэсгийн байрны барилгын ажлуудад комиссын гишүүдийн үзлэг шалгалт хийсэн дүгнэлт байхгүй байна. Энэ нь ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тушаалаар батлагдсан Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийн 4.6-д “*Зураг төсөл зохиогч, захиалагч.....гүйцэтгэгч талууд хамтран тухайн барилгад тенхикийн болон чанарын үзлэг, шалгалт хийж дотоодын хяналтын дүгнэлт гаргана*” гэж заасныг зөрчиж байна.

3.6 ТАХ-г улсын комисс холбогдох дүрмийн дагуу хүлээн аваагүй байна.

3.6.1 Эрх шилжиж ирсэн зарим ТАХ-г улсын комисс зохих дүрэм журмын дагуу хүлээн авч ашиглалтад оруулаагүй байна. Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн барилгын фасад, шат, довжоо, цахилгааны засвар, Хатанбулаг сумын Ханги Боомтод баригдсан Цагдаагийн хэсгийн байрны барилгын ажил дуусаагүй, гүйцэтгэл дутуу байхад улсын комисс ашиглалтад оруулсан байна. Энэ нь ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тушаалаар батлагдсан Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийн 4.12.6-д “*Барилга байгууламж, тоног төхөөрөмж, засварын ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн....., техникийн нөхцөлийн заалтын шаардлага хангаагүй,.....захиалагч, зураг төсөл зохиогчийн тавьсан шаардлага дүгнэлтийн биелэлтийг хангаагүй тохиолдолд комисс ажиллахаас татгалзах*” гэж заасны зөрчиж байна.

3.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим хөрөнгө чанар болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.

3.7.1 БСШУССайдын багцын хүрээнд 2016 онд нийлүүлэгдсэн зарим хөрөнгө чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна. Тухайлбал, Даланжаргалан сумын дотуур байранд 2016 оны 2-р сард Сухайт хайрхан ХХК-аас 37 ширхэг давхар ор нийлүүлсэний 3.2 сая төгрөгийн 18 ширхэг ор нь эрэг боолт, тавцан модгүй, 30 ширхэг хувцасны шкафын 4.6 сая төгрөгийн 20 ширхэг нь эрэг боолт дутуу ирсэн шалтгаанаар угсраагүй жил гаруй хайрцагтайгаа хураалттай байна.

Зураг 11. Эрэг боолт тавцангүй ор



Зураг 12. Эрэг боолт ирээгүй шкаф



3.7.2 ЭМС-ын багцын хүрээнд 2016 онд шинээр нийлүүлсэн нийт 22.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна. Тухайлбал: Нэгдсэн эмнэлгийн цусны банкны хөргөгч нь тээвэрлэлтийн явцад температур заагчид гэмтэл гарсан, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт нийлүүлэгдсэн 7 ширхэг компьютерийн үйлдлийн систем нь гацдаг.

3.7.3 Салбар сайдын багцын хүрээнд 2016 онд нийлүүлсэн зарим хөрөнгө оруулалтын үр ашиг хангалтгүй байна. Тухайлбал:

- Даланжаргалан сумын дотуур байранд БСШУССайдын багцаас 2016 онд 12.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн бөгөөд үүнээс 6.9 сая төгрөгийн хөрөнгө илүүдэлтэй, ашиглалтгүй агуулахад хадаглагдаж байна.
- Сайншанд сумын 9-р цэцэрлэгт 11.0 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсний 5.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй, илүүдэлтэй агуулах болон айлын гаражад хадгалаастай байна.
- Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд ЕБ-ын сургуульд нийлүүлсэн 103.5 сая төгрөгийн 15 ш ухаалаг самбарыг багш нарт тухайн самбарын ашиглалтын талаар заавар, зөвлөгөө өгөөгүйгээс ашиглалтгүй байна.

3.7.4 ЭМС-ын багцын хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн нийт 92.6 сая төгрөгийн дизель цахилгаан үүсгүүр нь ашиглалтгүй байна. Уг төхөөрөмжийг зориулалтын байр бэлтгэн суурилуулсны дараа ашиглах тул байгуулагын агуулах, гражид хадгалж байна. 2016 онд шинээр нийлүүлэгдсэн ашиглалтгүй хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар харуулав.

3.7.5 АХБ-ны болон улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих "Өмнөговь, Дорноговь аймгуудын хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил" төслийн хүрээнд Замын-Үүд суманд хэрэгжүүлсэн 167.0 сая төгрөгийн Хог

шахагч тоног төхөөрөмжийг ашиглагч ЗҮ НААҮ ОНӨХХК нь хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

3.7.6 Нэгдсэн эмнэлгийн А блокийн мэс тасгийн засварын ажлыг 2013 онд нэмэлтээр гүйцэтгэсэн байна. Засварын ажлыг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

3.7.7 БСШУСС-ын багцын хөрөнгө оруулалтаас УИХ-ын гишүүдээр дамжуулан 13 байгууллагад олгосон 14.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 10 байгууллагад олгосон 16.2 сая төгрөгийн хөрөнгийг 15.3 сая төгрөгөөр үнэлж нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тусгуулсан байна. Дээрх бүртгэлд тусгаагүй буюу үнийн дүн зөрүүтэй тусгагдсан хөрөнгийг НББ-д тусгах албан шаардлагыг бичиж, аймгийн СТСХ-т хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашиг сэдэвт аудитаар нийт 1738.4 сая төгрөгийн зөрчил ирлүүлснээс 1320.9 сая төгрөгийн 5 албан шаардлага бичиж, 363.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт:

Зөвлөмж 1. Сайншанд сумын 5-р сургуулийн сагсны талбайн хагарсан хэсэг, халзарсан будгийн ажлыг дахин хийлгэн засварлуулах.

Хэрэгжилт. ГХБХБГ-ын 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн 342 тоот албан бичгээр гүйцэтгэгч Их Түмэн эрдэнэ групп ХХК-д сагсны талбайн хагарсан хэсэг, халзарсан будгийн ажлыг дахин хийлгэн, засварлуулах талаар бичиг хүргүүлсэн боловч гүйцэтгэгч чанаргүй хийсэн ажлыг засварлах арга хэмжээ аваагүй байна.

Зөвлөмж 2. Хатанбулаг сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын чанаргүй хийсэн ажлыг засаж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилт. ГХБХБГ-аас гүйцэтгэгчид барилгын чанаргүй хийсэн ажлыг засварлуулах талаар удаа дараа албан бичгээр хандсан боловч тодорхой арга хэмжээ аваагүй байна. Иймээс тус газар нь Дорноговь аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу ХБС ХХК нь Хатанбулаг сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын чанаргүй хийсэн ажлыг бүрэн засварлаж 2016 оны 11-р сарын 29-ний өдөр хүлээлгэн өгсөн байна.

Зөвлөмж 3. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцон ажиллах

Хэрэгжилт. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцох ажлыг зохион байгуулж хийдэг боловч, зарим ажлын үр дүн хангалтгүй байна.

БҮЛЭГ 3.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

3. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих шат шатны хяналт дутагдаж байна.

3.1. Гэрээний нөхцөл тодорхойгүй, талууд гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчил гарсаар байна.

3.1.1 Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлэх зарим ТАХ-нүүдийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд ажил үйлчилгээ болон бараа нийлүүлэх хугацаа нь тодорхойгүй, санхүүжилт авсан үед ажил эхлэхээр заасан байна. Тухайлбал:

- Соёмбот цогцолборт эскитний талбай, дугуйн зам байгуулах 78.0 сая төгрөгийн төсөв бүхий ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг санхүүжилт орсон өдрөөс хойш 45 хоногийн дотор,
- Тоглоомын талбай байгуулах 12.0 сая төгрөгийн төсөв бүхий ажилд санхүүжилт орсон өдрөөс хойш 14 хоногийн дараа,
- ИХШХЕГ-ын Дорноговь аймаг дахь газарт авто машин худалдан авах гэрээнд урьдчилгаа санхүүжилт орсноос хойш 45 хоногийн дотор нийлүүлнэ.

3.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 16 ТАХ-ний гэрээний хугацаа хэтэрсэн байна. Гэрээний хугацааг 5-24 хоногоор хэтрүүлсэн гүйцэтгэгч нарт алданги тооцоогүй байна.

3.2. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөлт нь тооцоо, судалгаагүй хийгдсэнээс санхүүжих эх үүсвэр дутагдаж төсвийн гүйцэтгэл 69.1 хувьтай байна.

3.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2755.1 сая төгрөгийн 85 төсөл, арга хэмжээний төсөв батлагдсанаас 71 төсөл арга хэмжээнд 1964.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 35 төсөл арга хэмжээнд 1439.9 сая төгрөгийн, сумын хөрөнгө оруулалтаар 36 төсөл, арга хэмжээнд 524.9 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

3.2.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө болон ТАХ-г тооцоо судалгаагүй төлөвлөснөөс хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл 69.1 хувь байна.

3.2.3 Батлагдсан төсөв бүхий хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан арга хэмжээ байхгүй байна.

3.3. Хөрөнгө оруулалтын ажлуудад тавих хяналт хангалтгүйгээс гүйцэтгэл дутуу, гэрээний үүргээ биелүүлээгүй байхад урьдчилгаа санхүүжилт олгож үргүй зардал гаргасан байна

3.3.1 Аймгийн орон нутгийн төсвийн 2015 оны чөлөөт үлдэгдлээс дараах ажлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ороогүй ТАХ-г төсвийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжаар гарсан байна. Тухайлбал: Ханги мандалын суурьшлын бүсэд 800 м газар тог татах 5.2 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр Ханги шинэ суурьшлын бүсийн захиргаа Оновчтой шийдэл ХХК-тай гэрээ байгуулж, ажил хийгдээгүй байхад 5.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Оновчтой шийдэл ХХК-иар 5.7 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тавьсан.
- Сайншанд суманд шинээр баригдах цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулах 74.9 сая төгрөгийн ажлыг 2015 онд Говь тарвас ХХК гүйцэтгэсэн байна. 2016 онд 3.9 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан ба өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл 17.3 сая төгрөг, магадлашгүй ажлын зардал 1.3 сая төгрөг, нэмэлт ажлын санхүүжилт 3.9 сая төгрөг нийт 22.6 сая төгрөг олгосон

байна. Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашааны ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг арилгахад шаардлагатай хөрөнгийн тооцооллыг ГХБХБГ-аас 7.3 сая төгрөгөөр хийсэн бөгөөд ЗДТГ-аас Говь тарвас ХХК-аар ажлыг гүйцэтгүүлэхээр шүүхэд хандсан байна.

- Сайншанд Соёмбо цогцолборт 9.9 сая төгрөгөөр 5D кинотеатрын дотор хана угсрах, дуу тусгаарлалт хийх ажлыг 2016 оны 6 сард дуусгасанаас хойш зориулалтын дагуу ашиглаагүй, уг засварласан өрөөнд аймгийн Ахмадын хороо үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 17. Аймгийн Ахмадын хорооны ажлын байр

3.3.2. Аймгийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөр дараах ажлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Саран хөхөө театрын үзэгчдийн суудлын тоо 400 хүний хүчин чадалтай бөгөөд 2016 онд 460 сандал худалдан авсан байна. Хүлээн авсан сандлаас тус театрт 337 ширхэгийг суурилуулсан ба 15.8 сая төгрөгийн 123 ш сандал агуулахад хадгалагдаж байна.
- Цагдаагийн газарт нийлүүлэгдсэн 8.0 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг бэлэн бус торгуулийн mobil төхөөрөмж нь хурд бага, сүлжээ сайн барьдаггүйгээс үйлчлүүлэгч иргэдэд дараалал үүсгэж бухимдуулдаг байна. 2016 онд Замын цагдаагийн газраас уг загварын төхөөрөмжийг хангалт хийгдэхгүй байх санал өгч байсан байна.

3.3.3 Замын-үүд сумын төсвийн хөрөнгөөр дараах ажлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Гадаадын иргэн харъяатын Ерөнхий газрын харьяа Дорноговь дахь газарт 30.3 сая төгрөгийн үнэ бүхий суудлын авто машин нийлүүлэх ажлын тендерт шалгарсан Акватик ХХК-тай 2016 оны 3 дугаар сарын 21-нд гэрээ байгуулсан байна. Тус компанид 2016 оны 4 дүгээр сарын 6-нд урьдчилгаа 5.0 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд гэрээт хугацаандаа авто машиныг нийлүүлээгүй байна. Замын-Үүд сумын Захирагчийн албанаас Акватик ХХК-д гэрээгээ цуцлах, урьдчилгаа мөнгийг эргүүлэн төлөх тухай албан бичгээр мэдэгдсэн ч өнөөг хүртэл 5.0 сая төгрөгийг эргүүлэн төлөөгүй байна. Үүнд Замын-Үүд сумын Засаг даргад хариуцуулан шийдвэрлүүлэхээр 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт бичсэн.
- Замын-Үүд суманд бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан мэдээлэх ажлын хүрээнд 2016 оны 5 сард бүтээн байгуулалтын ажлын тайлангийн фото зураг авах, өрөлт хийх, эх бэлтгэлийг редакторлох ажилд иргэн З.Мөнхтөртэй 4.0 сая төгрөгийн гэрээ байгуулж 800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлыг дүрсжүүлэх, 3D хэлбэрээр танилцуулга видео хийх ажилд

Индэ Сигн студи ХХК-тай 8.0 сая төгрөгийн гэрээ байгуулж 1.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Уг ажлын гүйцэтгэлийг хүлээн аваагүй байсанд 2.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

3.4. Сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 7 жил үргэлжилж байна.

3.4.1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өргөн, Айраг, Даланжаргалан сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах 71.3 сая төгрөгийн ажлыг 2011 онд Шинэ хотжилт ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажлын дунд үе шатанд нийт 51.0 сая төгрөг санхүүжүүлсэн байна. ТАХ-ний санхүүжих дүнг өмнөх жилүүдэд дутуу баталснаас гэрээний нөхцлийн дагуу санхүүжүүлээгүй, ажлын гүйцэтгэл удааширсан ба 2014 онд уг компани татан буугдсан байна. 2016 онд тус ажлыг дуусгуулахаар 20.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.5. ТАХ-ний гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас чанаргүй ажил хийгдэх, гэрээний хугацааг хэтрүүлэх, ажлаа дутуу гүйцэтгэх зөрчил гарсаар байна.

3.5.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нүүдэд зохиогчийн болон захиалагчийн хяналт тавиулах гэрээ байгуулан ажилласан хэдий ч барилгын ажлын үе шат бүрт зохиогч болон захиалагч хяналт тавиагүй байна.

3.5.2 Иххэт суманд СНТ ХХК 734.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Спорт цогцолборын барилга угсралтын ажлыг чанаргүй материалаар гүйцэтгэснээс ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл гарсан байна. Тухайлбал барилгын ус зайлуулах хоолой хугаран унасан, цэвэр усны шугам удаа дараа хөлдсөн, өрөө танхимуудын хаалганы цоож, бариулууд салж унасан, барилгын хормойд наасан плитанууд ховхорч унасан, дээврээс ус гоожсон, гадаа талбай дахь гэрэл хүчтэй салхинд унасан байна. Хангалтгүй хийгдсэн ажлуудыг дахин засварлуулах албан шаардлага бичив.



Зураг 18. Иххэт сумын Спорт цогцолборын барилга

3.5.3 Замын-Үүд сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн засварын ажлуудын төсөв, гүйцэтгэл, нийлүүлэгдсэн бараа, тоног төхөөрөмжийн үнэ өртөг, явган зам, гэрэлтүүлгийн ажлуудын чанар байдалд тавих шат шатны хяналт байхгүй байна.

3.5.4 Замын-Үүд сумын Сүлд багт 12.0 сая төгрөгийн төсөв бүхий элсний волейбол, сагсны талбай байгуулах ажлыг Мөнгөн сүлд иргэдийн бүлэг 2015 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба өнөөг хүртэл ажлыг дуусгаагүй байна. 2016 онд 3.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Замын-Үүд сумын ЗАА-нд хариуцуулж ажил дуусгуулах албан шаардлага өгөв.

3.6 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн ажлуудад улсын комисс хүлээж аваагүй байхад ашиглалтад оруулсан болон санхүүжилтийг бүрэн олгосон ТАХ байхгүй байна.

3.7 Зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй, данс бүртгэлд тусгагдаагүй байна.

3.7.1 Замын-Үүд суманд багуудын хаяг шинэчлэн хийх 33.9 сая төгрөгийн ажлаар жижиг хаяг 2221, том хаяг 140, байшингийн хаяг 357, гудамжны хаяг 40 хийгджээ. Шинээр газар олгосон боловч айлууд буугаагүй байгаа гудамжнуудын хаяг, хашаагүй айлуудын гудамжинд хаяг байршуулах боломжгүйгээс хийгдсэн хаягуудын зарим хэсэг ашиглагдаагүй байна.



Зураг 19. Хаягнууд

3.7.3 Ногоон байгууламж тариалах ажлын усалгааны асуудлыг оновчтой шийдвэрлээгүйгээс хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлууд үр дүнгүй, чанаргүй байна.

- Замын-Үүд суманд хүнд даацын авто замын дагуу 9.8 га газарт ногоон зурвас байгуулахаар Эртний хаадын цэцэрлэгт хүрээлэн ХХК-тай 2015-2017 онуудад хэрэгжүүлэх 83.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. 2016 онд уг ажилд сумын төсвийн хөрөнгөөр 4.0 сая төгрөгийн, Замын-Үүд сангаас 12.0 сая төгрөг санхүүжүүлэх төсөв батлагдсан байхад 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгосон байна.
- Замын-Үүд сумын 3-р багт 2 дахь ойн зурвасын 2 га талбайд 2500 чацаргана тариалах 28.6 сая төгрөгийн гэрээг Гансуварга ТББ-тай байгуулсан байна. 2016 онд 3.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Замын-Үүд сумын 2-р багт 2.4 га талбайд ногоон байгууламж тариалж буй Баянзүрх эмэгтэйчүүд хөгжил ТББ-д Замын-Үүд сангаас 1.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төсөв батлагдсан байхад сумын төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлсэн байна.

3.7.4 Сайншанд сумын 2-р багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох ажилд 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр 100.0 сая төгрөг, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 56.9 сая төгрөгийн нийт 156.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Шугам сүлжээнд айл өрх холбогдоогүй байна.

3.7.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Сумын хөрөнгө оруулалтаар 2015-2016 онуудад хэрэгжсэн ТАХ-ний нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгуулах жагсаалтад ТАХ-г бөөн дүнгээр бичсэн учир Замын-Үүд НААҮ ОНӨХХК дансанд бүртгээгүй байна. Тухайлбал: Соёмбот цогцолборт байгуулсан эскитний талбай, дугуйн зам байгуулах ажил 78.0 сая төгрөг гэж жагсаалтад орсон бөгөөд дугуйн зам, скитний талбай, гэрэлтүүлгийн тоо хэмжээ, нэгжийн үнэ тодорхойгүй байна.
- Сумын хөрөнгө оруулалтаар 2015-2016 онд хэрэгжсэн 208.3 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн 7 ТАХ тус бүрт хөрөнгийн нэр төрөл, нэгжийн үнэ, тоо хэмжээг тодорхой болгож холбогдох байгууллагуудад хүргүүлэх албан шаардлагыг Замын-Үүд ЗАА-нд хариуцуулж бичлээ.

- Сайншанд сумын 1,2,3,5-р 58 айлын орон сууцнууд, Залуус хороолол, 4-р багийн төв талбай зэрэг газруудад нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах, хүүхдийн тоглоомын талбай байгуулах 73.3 сая төгрөгийн ажил хийгдсэн байна. Хөрөнгийг хаана эзэмшүүлэх нь тодорхойгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна. Сайншанд сумын ЗДТГ-т хариуцуулж бүртгэлд тусгуулах 73.3 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.
- Аймаг, сумын хөрөнгө оруулалтаар зураг төслийн байгууллагаар гүйцэтгүүлсэн зураг,ТАХ-г гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эскиз зураг, ажлын зураг, өртгийн төсөв зэрэг баримт бичгийг хаана бүртгэх нь тодорхойгүйгээс данс бүртгэлд тусгагдаагүй байна. Тухайлбал:
 - Сайншанд суманд баригдах 700 хүний суудалтай Спорт цогцолборын барилгын зураг төсөв 7.5 сая төгрөг
 - Сайншанд сумын багуудад хийгдэх авто зогсоолын зураг төсөв 9.9 сая төгрөг
 - Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 45.0 сая төгрөг
 - Сайншанд-Хамрын хийд чиглэлийн авто замаас “Ханбаян зүрх уул” хүртэлх 6.85 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын төсвийг шинэчлэн боловсруулах 2.2 сая төгрөг
 - Сайншанд сумын 8-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зурагт холболт хийх зураг төсөв 20.3 сая төгрөг
- Дээрх 84.9 сая төгрөгийн зураг төсвийг НББОУС-д нийцүүлж холбогдох газарт хариуцуулан данс бүртгэлд тусгуулахын зэрэгцээ сүүлийн жилүүдэд хийгдсэн зураг төслийн ажлуудыг данс бүртгэлд тусгагдсан эсэхийг нягтлан судалж, бүртгэх асуудлыг СТСХ, ГХБХБГ-т хариуцуулж албан шаардлага бичлээ.
- Замын-Үүд сумын 1 дүгээр багийн 10 дугаар хэсгийн тохижилтын 2.0 сая төгрөгийн зураг төсөл, шинээр байгуулах хогийн цэгийн байр зүйн 1.5 сая төгрөгийн зураг төсөл, 1 дүгээр сургуулийн барилгын өргөтгөлийн 4.0 сая төгрөгийн зураг төслүүдийг данс бүртгэлд тусгуулах 7.5 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд хийсэн аудитаар нийт 1870.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.6 сая төгрөгийн төлбөрийн 3 акт, 386.0 сая төгрөгийн 7 албан шаардлага бичиж 1471.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Өмнөх аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт:

Өмнөх аудитаар 7 зөвлөмж өгөгдсөнөөс дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

1. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаа урьдчилж судлах, үнэлэх, үр өгөөжийг тооцох, эх үүсвэрээ үр ашигтай хуваарилах
2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгуулах
3. Захиалагч болон гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллах

Өмнөх аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд 674.3 сая төгрөгийн 5 албан шаардлага бичсэнээс 419.4 сая төгрөгийн албан шаардлага биелээгүй бөгөөд Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, 2 гүйцэтгэгч компани баталгаат хугацаандаа ажлаа засварлаж дуусгаагүй байна.

БҮЛЭГ 3. ДҮГНЭЛТ

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй байхад санхүүжилт олгож үргүй зардал гаргасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсан, зураг төсвийн алдаа, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэргээс ТАХ-ний хэрэгжих хугацаа хойшлогдсон байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас чанаргүй ажил хийгдэх, ажлаа дутуу гүйцэтгэх, хугацаа хэтрүүлэх, хуурамч гүйцэтгэл гаргах зөрчил гарсаар байна.

Улс, орон нутагт хэрэгжсэн зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ 3. ЗӨВЛӨМЖ

1. Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцлийг тодорхой тусгаж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллах
2. ТАХ-ний гүйцэтгэлийн үе шат бүрт шат шатны хяналтыг хэрэгжүүлж, чанартай гүйцэтгүүлэх, батлагдсан хугацаанд ашиглалтад хүлээн авах
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжсэн ТАХ-ний ашиглалт, түүний үр ашиг, үр нөлөөг сайжруулах. Үүнд:
 - Ашиглагдаагүй, илүүдэлтэй хөрөнгийг бусад шаардлагатай газарт оновчтой хуваарилах,
 - Үйлчилгээний чиглэлээр баригдсан барилгын ашиглалтыг сайжруулахад иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж ажлын байртай болгох
 - Цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалтыг сайжруулахад чиглэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж хэрэгжүүлэх
 - Ногоон байгууламжийн усалгааны системийг боловсронгуй болгох асуудлыг цогцоор шийдвэрлэх
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-г данс бүртгэлд тусгуулах

Бүлэг 4

Векселиэр санхүүжүүлж, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах боловсон хүчний мэдлэг, ур чадвар дутагдсанаас хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөж хангалтгүй байна.

А. Векселиэр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт бодитой байна.

А.1 УИХ, ЗГ-ын тогтоолоор нийт 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г эрх шилжүүлэн векселиэр санхүүжүүлэхээр батлагдсан байна.

А.1.1 МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуулиар Шадар сайд, ЗГХЭГ, БСШУСС-ын багцаас захиалагчийн эрх шилжүүлэн тус аймагт хэрэгжүүлж, векселиэр төлбөр гүйцэтгэсэн 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-нд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна.

Хүснэгт 4. 2016 оны Төсвийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт (сая төгрөг)

Хөрөнгө оруулалтын ангилал		2015.11.13-ны 2016 оны Төсвийн тухай хуулиар			2016.9.9-ны өдрийн тодотгол 4-р хавсралт		
		ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	шинэ						
	шилжих				4	2778.3	699.6
Их засвар	шинэ						
	шилжих	1	180.0	82.7			
Тоног төхөөрөмж	шинэ				2	133.9	133.9
	шилжих				1	44.6	44.6
ДҮН		1	180.0	82.7	7	2956.8	878.1

А.1.2 Хуулийн өөрчлөлтөөр анх батлагдсан санхүүжих нийт дүн 795.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Барилга байгууламжийн ТАХ 4-өөр буюу санхүүжих дүн 699.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, тоног төхөөрөмж худалдан авалт 3-аар буюу 178.5 сая төгрөгөөр санхүүжихээр хуульчлагдсан байна.

А.1.3 2016 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөрөнгө оруулалтын 4 ТАХ-нд 699.6 сая төгрөг, их засварын шилжих 1 ТАХ-нд 82.7 сая төгрөг, тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-нд 127.9 сая төгрөг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

А.1.4 Хатанбулаг сумын соёлын төвийн БУА 2012 онд эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Барилгын ажлын санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгож байгаагүй. 2016 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор санхүүжилтийн үлдэгдэл 46.6 сая төгрөгийг векселиэр батгалгаажуулахаар шийдвэрлэсэн.

А.1.5 Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар /шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжүүлсэн төсөл/-ийн хүрээнд ЗГХЭГ-

ын 2013 оны ХЭГ/1706 тоот албан бичгээр аймгийн оношлогооны төвийг байгуулах 180.0 сая төгрөгийн байрны засвар, тохижилтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрх шилжүүлжээ.

- Аймгийн Засаг даргын 2013 оны А/120 тоот захирамжаар томилогдсон үнэлгээний хороо ХАА зохион байгуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийн В блокын 1, 2 давхарын засварын ажлыг 154.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 2013 оны 12-р сарын 16-ны өдөр НТШ-УТ-17/2013 тоот гэрээг, засварын нэмэлт ажлыг 23.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 2014 оны 02-р сарын 21-ний өдөр НТШ-УТ-17/2013-1 тоот гэрээг Зэс Орд ХХК-тай байгуулсан байна. Ажил эхэлснээс хойш нийт 178.5 сая төгрөгийн гүйцэтгэлд 95.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Гэрээний дагуу ажил бүрэн хийгдсэн, 2016 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор санхүүжилтийн үлдэгдэл 82.7 сая төгрөгийг векселиэр батгалгаажуулсан.

А.1.6 Шадар сайдын багцаас эрх шилжүүлэн тус аймагт хэрэгжүүлсэн Замын-Үүдийн дэд бүтцийн байгууламжийн зураг, төслийг боловсруулах ажлыг 780.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр /ХААГ-3-2013/ХИ-5 тоот гэрээг 2013 онд байгуулагдсан бөгөөд Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК ажлыг бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 2014 онд 390.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 2016 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, ЗГ-ын тогтоолоор үлдэгдэл 390.4 сая төгрөгийг векселиэр батгалгаажуулсан.

А.1.7 БСШУСС-ын багцаас эрх шилжүүлсэн Даланжаргалан сумын Соёлын төвийн барилга 2012 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 630.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Барилга байгууламж ашиглалтад оруулах Улсын комиссын 2015 оны 77/15 тоот актаар барилгыг хүлээн авч ашиглалтад оруулсан. 2015 онд зураг төсөвт магадлал хийлгэж улсын төсвөөс 454.1 сая төгрөг нэмж батлагдан 241.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2016 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр 212.6 сая төгрөгийг векселиэр баталгаажуулсан байна. Аймгийн орон нутгийн чөлөөт үлдэгдэлээс 2016 онд БУА-ын орон нутгийн төсвөөс санхүүжих үлдэгдэл 36.7 сая төгрөгийн санхүүжүүлтийг олгосон байна.

А.2 Векселиэр санхүүжүүлэхээр ЗГ-ын тогтоолд тусгагдаж байсан ТАХ-г МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад тусгаж баталсан байна.

А.2.1 УИХ, ЗГ-ын тогтоолоор 2012-2014 онуудын хөрөнгө оруулалтад тусган бүрэн хэрэгжүүлж дууссан гэрээний дагуу үлдэгдэл, урьдчилсан гүйцэтгэл нь 80 хувиас дээш гүйцэтгэлтэй, санхүүжилтийг бүрэн олгож чадаагүй 5 ТАХ-г векселиэр баталгаажуулан, 2016 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр баталсан байна.

Хүснэгт 5. Векселиэр баталгаажуулан, батлагдсан ТАХ

ТАХ, барилга байгууламжийн жагсаалт	Төсвийн тухай хууль 2015-11-13	Тодотголоор 4-р хавсралт 2016-09-09	УИХ-ын 07 тогтоол 2015-01-23	ЗГ-ын 282 тогтоол 2015-7-7	72 тогтоол ЗГ-ын 2016-2-1
Замын-Үүдийн 2 дугаар ээлжийн дэд бүтцийн байгууламжийн зураг, төслийг боловсруулах	-	Век-II.2.1.6	-	2-р хавсралт	-
Соёлын төвийн барилга /Дорноговь, Даланжаргалан/	-	Век-X.2.1.4	-	-	1-р хавсралт
Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг/	-	Век-X.4.1.10	-	3-р авсралт	-
Сургуулийн барилга, 928 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	XII.1.1.139	Век-X.1.1.110	хавсралт	1-р авсралт	-

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар	XVII.1.2.4	Век-ХIII.1.2.5	-	2-р хавсралт	-
Боловсролын салбарын тоног төхөөрөмж: /Улсын хэмжээнд/		Век-Х.1.3.3			
Малчдын хүүхдийг гэр цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролд хамруулах арга хэмжээ /Улсын хэмжээнд/		Век-Х.1.3.2			
Соёлын салбарын тоног төхөөрөмж		/Век-Х.2.3.1/			

А.3 МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, УИХ болон ЗГ-ын тогтоолд эрх шилжүүлсэн ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүн нэмэгдэж батлагдаагүй байна.

А.3.1 ЗГ-ын 2015 оны 282-р тогтоолын 2-р хавсралтаар Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засварын ажлын векселиэр баталгаажуулах дүнг 43.7 сая төгрөгөөр гэж батласныг ЗГ-ын 2015 оны 388-р тогтоолоор 82.7 сая төгрөг гэж залруулсан байна.

А.4 Орон нутагт эрх шилжүүлэн векселиэр санхүүжүүлэх ТАХ хууль болон ЗГ-ын тогтоолд давхар тусгагдаагүй байна.

Б. Векселиэр санхүүжүүлсэн зарим ТАХ-ийн ашиглалт хангалтгүй байна.

Б.1 Гүйцэтгэл гараагүй ТАХ-г векселиэр санхүүжүүлсэн байна.

Б.1.1 Замын-Үүд сумын 928 хүүхдийн сургуулийн БУА-ыг 2013 онд Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 27/2013 тоот актаар хүлээлгэн өгсөн. Сургуулийн гадна тохижилтын талбай, хамгаалалтын хашааны ажлын гүйцэтгэл гараагүй, ажил дутуу хийгдсэн байхад 50.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг векселиэр олгосон байна. ҮАГ-т энэ талаар дахин хяналт хийлгүүлэхээр уламжиллаа.

Б.1.2 Ашиглагч байгууллага дутуу ажлыг гүйцэтгүүлэх талаар гүйцэтгэгч болон БСШУСЯ, БХТ, ГХБХБГ зэрэг холбогдох байгууллагуудад жил дараалан хүсэлт явуулсан боловч шийдэгдээгүй байна. Гүйцэтгэгч Аж констракшн ХХК нь гэрээний үлдэгдэл санхүүжилтээр дутуу ажлуудыг хийж гүйцэтгэх талаар холбогдох байгууллагуудад тайлбар хүргүүлж байжээ.

Б.2 Төсвийн тухай хууль, УИХ, ЗГ-ын тогтоолоор батлагдсан ТАХ-г векселиэр санхүүжүүлсэн байна.

Б.2.1 Төсвийн тухай хууль, УИХ, ЗГ-ын тогтоолоор батлагдсан ТАХ-г векселиэр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 5. Векселиэр санхүүжүүлсэн ТАХ		сая төгрөгөөр	
Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжих дүн	Санхүүжилт	
Замын-Үүдийн 2 дугаар ээлжийн дэд бүтцийн байгууламжийн зураг, төслийг боловсруулах	390.4	390.4	
Соёлын төвийн барилга /Дорноговь, Даланжаргалан/	212.6	212.6	
Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг/	46.6	-	
Сургуулийн барилга, 928 суудал /Дорноговь, Замын-Үүд/	50.0	50.0	
Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар	82.7	82.7	

Боловсролын салбарын тоног төхөөрөмж: /Улсын хэмжээнд/	127.9	127.9
Малчдын хүүхдийг гэр цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролд хамруулах арга хэмжээ /Улсын хэмжээнд/	6.0	6.0
Соёлын салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	44.6	44.6
дүн	960.8	914.2

Б.3 Векселиэр санхүүжүүлсэн зарим ТАХ-ийн ашиглалт хангалтгүй, зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Б.3.1 Сайдын багцаас нийлүүлсэн зарим хөрөнгийн тоо хэмжээ дутуу, хөрөнгийн ашиглалт, үр ашиг хангалтгүй байна. Тухайлбал: Соёлын салбарын тоног төхөөрөмж /Век-Х.2.3.1/ төслийн хүрээнд БСШУСС-ын багцын хөрөнгө оруулалтын БСШУЯ-ны ТТ2014-13 №3/268 тоот гэрээний дагуу 2016 онд Айраг сумын Соёлын төвд 44.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэхээс 40.3 сая тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн байна. 4.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж дутуу ирсэн байна. ҮАГ-т энэ талаар дахин хяналт хийлгүүлэхээр уламжиллаа.

Б.3.2 Малчдын хүүхдийг гэр цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ /Век-Х.1.3.2/: төслийн хүрээнд Улаанбадрах сумын цэцэрлэгт нэг бүр нь 2.9 сая төгрөгийн 2 ширхэг иж бүрэн гэр нийлүүлсэн бөгөөд хөрөнгийн бүртгэлд 4.4 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Б.3.3 Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Век-Х.1.3.3/: төслийн хүрээнд Дорноговь аймгийн ЕБ-ын 6 сургуульд нийлүүлсэн 127.9 сая төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг Dot Pattern License Redberry /Дижитал үзэг/, Interactive White Board /Цэгэн хээтэй шилэн самбар/, Projector /Ойрын тусгалын проектор/ зэрэг тоног төхөөрөмжүүд нь программ суулгаагүй, ажиллуулах зааварчилгаа өгөгдөөгүйгээс ашиглалтгүй байна.

Б.3.4 Замын-Үүдийн дэд бүтцийн байгууламжийн зураг, төслийг боловсруулах 780.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг /ХААГ-3-2013/XII-5 тоот гэрээний дагуу Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК гүйцэтгэн 2013-2014 онд зураг төслийг Замын-Үүдийн Чөлөөт бүсийн захирагчийн албанд хүлээлгэн өгсөн байна. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дээрх зураг төслийг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна

Б.3.5 Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар /Шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжсэн төсөл/: Век-ХIII.1.2.5 төслийн хүрээнд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн засвар хийгдсэн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгийн В блокын 1,2-р давхарын засварын 178.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг /НТШ-УТ-14/2013/ гэрээний дагуу Зэс Орд ХХК гүйцэтгэн 2014 оны 12/2014 тоот актаар барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг 178.5 сая төгрөгийн засварын ажлыг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байгаад албан шаардлага бичив.

Б.4 Векселиэр олгосон санхүүжилт, БУА-ын гэрээгээр олгох нийт санхүүжилтийн дүнгээс хэтрээгүй байна.

Хүснэгт 4 Векселиэр санхүүжүүлсэн ТАХ сая төгрөгөөр.

ТАХ-ны нэр байршил	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл	Векселиэр олгосон
Замын-Үүдийн 2 дугаар ээлжийн дэд бүтцийн байгууламжийн зураг, төслийг боловсруулах	780.8	390.4	390.4	390.4
Соёлын төвийн барилга /Дорноговь, Даланжаргалан/	1084.1	871.5	212.6	212.6
Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг/	913.4	866.8	46.6	-
Сургуулийн барилга, 928 суудал /Дорноговь, Замын-Үүд/	2743.3	2693.3	50.0	50.0
Дорноговь аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар	178.5	95.8	82.7	82.7
Боловсролын салбарын тоног төхөөрөмж: /Улсын хэмжээнд/	127.9	-	127.9	127.9

Б.5.Вексель бичигдсэн дүн, хүүгийн зардлын тооцоо нийлсэн акт, векселиэр санхүүжилт авсан гүйцэтгэгч ТЕЗ-тай тооцоо нийлж магадлашгүй ажил, норм норматив, зураг төсөв, техник хяналтын зардлыг буцаан төвлөрүүлсэн, ЗГ-ын өрийн бүртгэлд векселийн төлбөрийг бүрэн бүртгэж тайлагнасантай холбоотой баримт байхгүй тул тайланд тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

УИХ,ЗГ-ын тогтоолоор нийт 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-г эрх шилжүүлэн, 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Векселиэр санхүүжүүлсэн зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй, бүртгэлд тусгагдаагүй байна.

Боловсролын салбарт нийлүүлэгдсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ажиллуулах сургалт зохион байгуулагдаагүйгээс хөрөнгийн ашиглалт хангалтгүй, агуулахад хадгалагдаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

БҮЛЭГ 4. ЗӨВЛӨМЖ

1. Боловсролын салбарт нийлүүлэгдсэн ухаалаг самбар, техник хэрэгслийг ажиллуулах багш ажилчдад сургалт зохион байгуулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх
2. Векселиэр санхүүжүүлсэн ТАХ-г данс бүртгэлд бүрэн тусгах

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх ТАХ нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлага, хүчин чадал, хөрөнгийн хангамж, орон нутгийн онцлог, урьд онуудад хуваарилагдсан хөрөнгө зэргийг судлалгүйгээр хөрөнгө төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ИТХ-нь хяналтын төсөв, зураг төсөлгүй, үр ашигтай эсэх нь тодорхой бус ТАХ-нд төсөв баталсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашгийг бууруулж байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад 757.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн нь төсвийн тухай хуулиар заасан орон нутгийн төсвийн чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаандаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.4-т заасан шалгуурыг харгалзан үзэх хэрэгтэй байна.

Үнэлгээний хороог журмын дагуу байгуулж ХАА-ны аргыг зөв сонгосон хэдий ч зохион байгуулсан ХАА-ны тайлагналыг үнэн зөв гаргаагүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй байхад санхүүжилт олгож үргүй зардал гаргасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсан, зураг төсвийн алдаа, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэргээс ТАХ-ний хэрэгжих хугацаа хойшлогдсон байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд тавих хяналт дутагдсанаас чанаргүй ажил хийгдэх, ажлаа дутуу гүйцэтгэх, хугацаа хэтрүүлэх, хуурамч гүйцэтгэл гаргах зөрчил гарсаар байна.

Улс, орон нутагт хэрэгжсэн зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар нийт 3608.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж 12.6 төгрөгийн 3 төлбөрийн акт, 1706.9 сая төгрөгийн 12 албан шаардлага бичиж 1889.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр танаа:

1. Хөрөнгийн үр ашиг, үр өгөөж, үр дүнд хүрэх тооцоо, ТАХ-ний хяналтын төсөв, зураг төсөл бүрэн эсэхийг нягталж хөрөнгө оруулалтын төсөв батлах
2. Төсвийн тухай хуулийн 4.1.24-т заасан "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасныг анхаарч төсөв батлах

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлага, эдийн засаг, үйл ажиллагаа, цаг хугацааны хувьд хэрэгжих боломж байгаа эсэх, үр өгөөж, үр нөлөөг тооцож үнэлгээ хийн төрийн захиргааны байгууллага болон аймгийн ИТХ-д хүргүүлэх
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжсэн ТАХ-ний ашиглалтыг сайжруулах

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг танаа:

1. ТАХ-ний гүйцэтгэлийн үе шат бүрт шат шатны хяналтыг хэрэгжүүлэх, чанартай гүйцэтгүүлэх, батлагдсан хугацаанд ашиглалтад хүлээн авахад анхаарч ажиллах
2. Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцлийг тодорхой тусгаж, гэрээг дүгнэж ажиллах
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгуулах
4. Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, ХАА, санхүүжилт, ашиглалтад хяналт тавьж ажиллах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас: (705) 2-25-33, факс: (705) 2-23-30
E-mail: dornogobi_mgl@yahoo.com

№ 17-04-26 № 1/871
танай 2017-04-24 ны № 1-6/396 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

“Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг төслийн байдлаар ирүүлснийг хүлээн авч танилцлаа.

Аудитын тайлангаар холбоотой дараах хэд хэдэн санал хүргүүлж байгааг хүлээн авч танилцан тайланд тусгагдсан аудитын мэдээллийг хянаж үзнэ үү. Үүнд:

1. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн 1.2.4 дэх хэсэгт *Аймгийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөр арга хэмжээнд он дараалан тусгагдаж хэрэгжүүлж буй гэр хороололын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэл иргэдийн амьдрах нөхцөл байдалд үр ашиг, үр өгөөжөө өгөөгүй, 2013-2016 онд нийт 39 өрх цэвэр усны шугаманд холбогдсон гэж дүгнэлт өгсөн байна.*

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлсэн гэр хороололын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын зорилго нь айл өрхийг шугам сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлж өгөх явдал юм. Тус ажлын үр дүнд шугам сүлжээнд холбогдох боломж бүрдсэн нийт өрхийн хэмжээгээр тус ажлын үр ашиг тооцогдоно.

Иргэдийн нийтийн хурлаар айл өрхүүд, ерөнхий шугмын гаргалгааны худгаас гэр хүртлэх шугам болон холболтын ажлуудыг бие даан гүйцэтгэж ашиглаж ажиллана гэж цэвэр бохир шугам тавиулах хүсэлтээ гаргасан.

2. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн 1.1 дэх хэсэгт *Төсөл арга хэмжээг аймаг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан ч хуулиар заасан чиг үүрэгт хамаарахгүй 757,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн гэжээ.*

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1 дэх заалтад тусгагдсан Засаг даргын бүрэн эрхэд “Нутаг дэвсгэрийн

2 2163

эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” ажил багтсан.

Монгол улсын эдийн засгийн байдал, улсын төсвөөс аймаг орон нутагт хөрөнгө оруулалт бага хийгдэж байгаа тул орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Улсын төсвийн харъяаны байгуулагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийхээс өөр аргагүй байдалд хүрч байгаа болно.



Т.ЭНХТҮВШИН

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хүлээн аваад дараах тайлбарыг өгч байна.

1. Аудитын дүнгийн 1.2.4 дэх хэсэгт өөрчлөлт орууллаа.
2. Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасныг цаашид анхаарч ажиллах тухай нэгдсэн дүгнэлтэд залруулж бичлээ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 20

Дугаар 1-6/07.

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тоот тушаалын хавсралтын 11 “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Засгийн газраас олгосон векселийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

4.Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэгт үүрэг болгосугай.

5.Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



0824819